



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 236

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

“Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг зөрчиж худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 37.5 сая төгрөгийн худалдан авалт хийсэн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг зөрчиж 64.7 сая төгрөгийн арга хэмжээг бүрдэл дутуу баримтаар санхүүжүүлсэн, Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-д заасан “Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” заалтыг зөрчиж 351.2 сая төгрөгийн үргүй зардал гаргасан зэрэг нийт 453.4 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн захирал Р.Нямтуулд санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:ь

2.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах;

2.2. Худалдан авах ажиллагаанд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, Сангийн сайдын 2017 оны 363 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

2.3. Компанийн бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний боловсруулалтыг сайжруулж, хяналт тавьж ажиллах;

2.4. Гадаад, дотоод албан томилолтын хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, эрх бүхий байгууллага, удирдах албан тушаалтны удирдамж, томилолтгүй ажилладаг явдлыг дахин гаргахгүй байх;

2.5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг зөрчин санхүүгийн бүрдэл дутуу баримтаар хийгдсэн ажил гүйлгээний баримтыг нөхөн бүрдүүлэх;

2.6 Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөөний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх,

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн Хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



З.МЭНДСАЙХАН

Ц. ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2020 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн
236 дугаар тогтоолын хавсралт

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авалт	Захирал Р.Нямтуул, Ерөнхий ня-бо Н.Отгонтунгалаг	37.520.00	Холбогдох журмыг мөрдөж ажиллах
2	Үндсэн баримтгүй зарцуулсан хөрөнгө	Захирал Р.Нямтуул, Ерөнхий ня-бо Н.Отгонтунгалаг	64,682.30	Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4-д заасан "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтыг мөрдөж ажиллах
3	Байгууллагын үйл ажиллагаатай холбоогүй үргүй зардал	Захирал Р.Нямтуул, Ерөнхий ня-бо Н.Отгонтунгалаг	351,210.05	Монгол Улсын "Төсвийн тухай хууль"- ийг мөрдөж ажиллах
	Дүн		453,412.35	